

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН “ОРОН НУТАГ ХӨГЖЛИЙН
САН”-ИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН АЖЛЫН
ТАЙЛАН**

2019.12.25

Шивээговь сум

АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ:

Нэг. Ажил

- 1.1. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн урсгал засвар
- 1.2. Орон нутгийн өмчийн барилга байгууламжид засвар хийх /3-р цэцэрлэгийн барилгын сантехникийн засварын ажлыг хийх/
- 1.3. Төв талбайг тохижуулах, усан оргилуур байгуулах

Хоёр. Бараа

- 2.1. Орон нутгийн өмчид шинээр өмч бий болгох /Сургуулийн ширээ сандал худалдан авах/
- 2.2. Үүрдэг хогийн савыг нэмэгдүүлэх
- 2.3. Орон нутгийн өмчид шинээр өмч бий болгох /Мэдээллийн хэрэгсэл худалдан авах/

Гурав. Төсөл, хөтөлбөр

- 3.1. Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөр, “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр
- 3.2. Баяр наадмын зардал
- 3.3. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж золбин нохой, муур устгах, хяналт тавих
- 3.4. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг сайжруулах, тохижилт хийх
- 3.5. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын зардал

Дөрөв. Зөвлөх үйлчилгээ

- 4.1. Төв талбайг тохижуулах, усан оргилуур байгуулах ажлын зураг төсөв
- 4.2. Суманд цэвэрлэх байгууламж байгуулах зураг төсөв
- 4.3. Суманд хатуу хучилттай засмал зам тавих зураг төсөв
- 4.4. Шивээговь суманд 1:1000-ны масштабтай байр зүйн зураг үйлдэх, боловсруулах

АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ:

Нэг. Ажил

1.1. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлгийн урсгал засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог сумын Засаг даргын 2019 оны 06 сарын 28-ны өдрийн А/104 дүгээр захирамжаар байгуулж, 2019.07.01-ний өдөр цахим тендерийг зарлаж, 1 тендер ирүүлснийг 2019.07.09-ний өдөр нээж, үнэлэн "Сүмбэр старлет" ХХК-ийг шалгаруулсан.

"Сүмбэр старлет" ХХК-тай 2019.07.25-ны өдөр гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлж, сумын Засаг даргын 2019.08.26-ны өдрийн А/130 дугаар захирамжаар томилогдсон комисс 2019.09.12-ны өдөр ажлыг хүлээж авсан.

Гэрээний дагуу төв зам дагуух 18 гэрэлтүүлэг, зүүн гэр хорооллын 9 шонгийн 18 гэрэлтүүлэг, сумын төвийн 4 гэрэлт цамхаг, 6, 7, 8 дугаар байрны нарны зайн 4 гэрэлтүүлэгүүдэд болон наадмын талбайд 6ш лед гэрэл тус тус суурилуулж, төв талбайн цамхаг болон 38 гэрэлтүүлгийн шонд чимэглэл байрлуулан зүүн гэр байрны цахилгааны тэжээлийн 60м кабелийг сольж засварласан. /Зураг-1/

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
"Сүмбэр старлет" ХХК	100%	15 000 000	14 986 895	14 237 550 /749345 төгрөг буюу чанарын баталгаа 5%-ийг холбогдох дансанд байршуулсан/	13 105

1.2. Орон нутгийн өмчийн барилга байгууламжид засвар хийх /3-р цэцэрлэгийн барилгын сантехникийн засварын ажлыг хийх/ ажлын шууд худалдан авалтыг зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын 2019 оны 05 сарын 21-ний өдрийн А/65 дугаар захирамжаар байгуулж, ажлын хэсгийн шийдвэрээр орон нутагт үйл ажиллагаа явуулдаг 3 байгууллагад ажлын урилгыг техникийн тодорхойлолтын хамт хүргүүлж, 1 байгууллага буюу "ОСО констракшн" ХХК үнийн санал ирүүлсэн.

2019.08.01-ний өдөр "ОСО констракшн" ХХК-тай 7.9 сая төгрөгийн гэрээ байгуулж ажлыг гүйцэтгүүлэн сумын Засаг даргын 2019.08.26-ны А/129 дугаар захирамжаар томилогдсон комисс 2019.09.02-ны өдөр ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан. Тус ажлын хүрээнд цэцэрлэгийн 250м халаалт, цэвэр усны шугамыг сольж шинэчилсэн. /Зураг-2/

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
"ОСО констракшн" ХХК	100%	8 000 000	7 967 110	7 967 110	32 890

Төв талбайг тохижуулах, усан оргилуур байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог сумын Засаг даргын 2019 оны 06 сарын 03-ны А/80 дугаар захирамжаар томилж, 2019 оны 06, 07 дугаар саруудад тендерийг 2 удаа зарлаж амжилтгүй болсон. Захиалагчаас ажлын тоо хэмжээнд өөрчлөлт оруулж бууруулан 2019.08-21-ний өдөр тендерийг дахин зарласан. Тендерийг 2019.08.29-ний өдөр нээж, 1 компани үнийн санал ирүүлж, "Оч хийц" ХХК-тай 2019.09.11-ний өдөр 49655929 төгрөгийн гэрээ байгуулсан. Ажлын гүйцэтгэл 70%. Хүйтний улирлаас шалтгаалж, гэрээний хугацааг 2020.05.25-ны өдөр хүртэл сунгасан. /Зураг-3/ Он дамжих ажил/

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
"Оч хийц" ХХК	70%	50 000 000	49 655 929	35 293 516	344 071

Хоёр. Бараа

2.1. Орон нутгийн өмчид шинээр өмч бий болгох /Сургуулийн ширээ сандал худалдан авах/ ажлын шууд худалдан авалтыг зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын 2019 оны 05 сарын 21-ний өдрийн А/64 дугаар захирамжаар байгуулж, 3 байгууллага, иргэнд ажлын урилгыг хүргүүлсэн.

Үнийн саналыг 2 байгууллагаас ирүүлж, "Мөнх авзага хайрхан" ХХК-ийг сонгон шалгаруулан бараа нийлүүлэх 9312000 төгрөгийн гэрээг 2019 оны 06 сарын 04-ний өдөр байгуулсан.

Сумын Засаг даргын А/123 дугаар захирамжаар томилогдсон комисс бага ангийн ширээ, сандал 70 ширхэг, дунд ангийн ширээ сандал 16 ширхэг, багшийн ширээ сандал 1ш, нийт 87 хос ширээ сандлыг 2019.08.15-ны өдөр хүлээж авсан. /Зураг-4/

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Мөнх авзага хайрхан” ХХК	100%	10 000 000	9 312 000	9 312 000	688 000

2.2. Үүрдэг хогийн савыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Засаг даргын 2019 оны А/40 дугаар захирамжаар шууд худалдан авалтыг зохион байгуулах ажлын хэсгийг томилж, Шивээговь сумын иргэн Д.Багжийбуутай гэрээ байгуулж, 2019.06.21-нд өдөр барааг хүлээн авсан.

Тус ажлын хүрээнд 2 ширхэг шинэ хогийн сав худалдан авч, хуучин 5ш хогийн савыг засварлуулсан. /Зураг-5/

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
Иргэн Д.Багжийбуу	100%	5 000 000	5 000 000	5 000 000	-

2.3. Орон нутгийн өмчид шинээр өмч бий болгох /Мэдээллийн хэрэгсэл худалдан авах/ ажлын шууд худалдан авалтыг зохион байгуулах ажлын хэсгийг Засаг даргын 2019 оны 01 сарын 29-ний өдрийн А/16 дугаар захирамжаар байгуулж, "Их зэст хайрхан" ХХК-тай 4970000 төгрөгийн гэрээ байгуулж, 2019 оны 06 сарын 18-ны өдөр Dell брендийн 2 ширхэг суурин компьютер, Dell брендийн 1 ширхэг зөөврийн компьютер, hp брендийн олон үйлдэлт 1 ширхэг принтерийг холбогдох актыг үйлдэж хүлээн авсан. /Зураг-6/

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
“Их зэст хөгжил” ХХК	100%	5 000 000	4 970 000	4 970 000	30 000

Гурав. Хөтөлбөр төсөл, арга хэмжээний зардал

3.1. Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөр, “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- 3.1.1. Суманд шагайн харваан аварга шалгаруулах тэмцээнийг 05 сард зохион байгуулсан.
- 3.1.2. “Байгаль орчноо хамгаалъя” аяныг 04 сард зохион байгуулсан.
- 3.1.3. “Гэр бүлийн баяр хөөр” сургалтыг 04 сард зохион байгуулсан.
- 3.1.4. “Хөгжөөнт бага нас” урлагийн тоглолтыг 06 сард зохион байгуулсан.
- 3.1.5. Малчдын зөвлөгөөнийг 03 сард зохион байгуулсан.
- 3.1.6. Аймгийн спортын наадамд тамирчдыг оролцуулсан.
- 3.1.7. Улсын чанартай 3 тэмцээн, олимпиадад нийт 40 хүүхдийг оролцуулсан.
- 3.1.8. “Угийн бичиг хөтлөлт” сургалтыг 254 өрхөд зохион байгуулсан.
- 3.1.9. Байнгын асаргааны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг хаврын витаминжуулалтанд хамруулсан.
- 3.1.10. Ахмад настнуудын дунд урлагийн арга хэмжээг 03 сард зохион байгуулсан.
- 3.1.11. Ахмадаа хүндэлье аян зохион байгуулсан.

3.1.12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд чиглэсэн аян зохион байгуулсан.

3.1.13. Аймагт 2019 оны 04 сард зохион байгуулагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн урлагийн наадамд иргэдээ оролцуулсан гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Мөрдөх журам	Батлагдсан төсөв	Зарцуулалт	Хүлээгдэж буй гүйцэтгэл
Шууд худалдан авалт	11 000 000	10 848 800	151 200

3.2. Баяр наадмын зардал. Баяр наадмыг зохион байгуулах комиссыг сумын Засаг даргын А/109 дүгээр захирамжаар томилж, баяр наадмын шагналын зардалд зарцуулсан. /Зураг-7/

Мөрдөх журам	Батлагдсан төсөв	Зарцуулалт	Хэмнэлт
Шууд худалдан авалт	5 000 000	5 000 000	0

3.3. Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж золбин нохой, муур устгах, хяналт тавих ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2019 оны 09 сарын 02-ны өдрийн А/134 дугаар захирамжаар томилж, 2019.10.21-ний өдөр, 2019.12.12-ны өдрүүдэд Улаанбаатар хотын иргэн Б.Будтай гэрээ байгуулж, нийт 193 золбин нохой, муур устгуулсан. /Зураг-8/

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хүлээгдэж буй гүйцэтгэл
Иргэн Б.Буд	100%	2 500 000	2 500 000	2 500 000	0

3.4. Нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн усалгаа арчилгааг сайжруулах, тохижилт хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2019 оны 04 сарын 19-ний өдрийн А/48 дугаар захирамжаар томилон 1-р багийн иргэн Ө.Ганбатыг сонгон шалгаруулж, 2019 оны 05 сарын 15-ны өдөр 3,332,703 төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулсан. Ажлын даалгаварт тусгагдсан хуваарийн дагуу төв талбай, цэцэрлэгт хүрээлэн, төв зам дагуух мод, наадмын талбайн зүлэгний усалгаа арчилгааг хийж, цэцэрлэгт хүрээлэнгийн сандал, хогийн савыг будаж, цэцгийн мандалд цэцэг тарьж ургуулсан.

Ажлын хэсэг, гүйцэтгэгчтэй хийсэн 2019 оны 10 сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрээр гэрээний үлдэгдэл 50%-ийн санхүүжилт 1666352 төгрөгийг гүйцэтгэгчид олгосон. /Зураг-9/

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
Иргэн Ө.Ганбат	100%	3 332 703	3 332 703	3 332 703	0

3.5. Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Засаг даргын 2019 оны 04 сарын 04-ний өдрийн А/43 Захирамжаар томилогдсон ажлын хэсэг Ажлын даалгаварыг боловсруулан батлуулж, 2019 оны 04 сарын 06-ны өдөр иргэн З.Билэгбаяртай 999000

төгрөгийн гэрээ байгуулж, сумын сайн дурын 15 иргэний гамшгаас хамгаалах ажлын хувцас, хэрэглэлийг худалдаж авсан.

Сумын Засаг даргын 2019 оны 08 сарын 16-ны өдрийн А/125 дугаар Захирамжаар Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль - Шивээговь сумыг нүүлгэн шилжүүлэх ажиллагааны зардалд 5001000 төгрөгийг зарцуулахаар төсөвлөж, зарцуулсан. /Зураг-10/

Шалгарч гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгосон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
Иргэн З.Билэгбаяр	100%	6 000 000	999 000	999 000	9 770
Нүүлгэн шилжүүлэх ажиллагаа	100%		5 001 000	4 991 230	

Дөрөв. Зөвлөх үйлчилгээ

4.1. Төв талбайг тохижуулах, усан оргилуур байгуулах ажлын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг сумын Засаг даргын 2019 оны 01 сарын 29-ний өдрийн А/14 дугаар захирамжаар томилж, "Би Ти Эл констракшн" ХХК-ыг сонгон шалгаруулсан. "Би Ти Эл констракшн" ХХК-тай ажил гүйцэтгэх 3000000 төгрөгийн гэрээ байгуулан гүйцэтгүүлж, сумын Засаг даргын 2019 оны 06 сарын 03-ны А/79 дугаар захирамжаар томилогдсон комисс холбогдох актыг үйлдэн хүлээн авсан. /Зураг-11/

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
"Би Ти Эл констракшн" ХХК	100%	3 000 000	3 000 000	3 000 000	-

4.2. Суманд цэвэрлэх байгууламж байгуулах зураг төсөв боловсруулах ажлын үнэлгээний хороог Засаг даргын 2019.05.21-ний өдрийн А/66 дугаар захирамжаар байгуулж, 2019.06.07-ны өдөр tender.gov.mn-д зарыг байршуулж, хураангуй жагсаалтад 3 байгууллагыг бүртгэсэн. Үнэлгээний хороог 2019 оны 06 сарын 25-ны өдөр хуралдуулж, зөвлөх үйлчилгээний тендерийн баримт бичгийг хураангуй жагсаалтанд орсон 3 байгууллагад хүргүүлсэн. Зөвлөхийн тендерийг 2019.06.26-ны өдөр зарлаж, 1 компанийн техникийн, санхүүгийн саналыг үнэлэн гэрээ байгуулах мэдэгдлийг "Гидродизайн инноваци" ХХК-д хүргүүлж, 2019.08.27-ны өдөр гэрээг байгуулсан. Гүйцэтгэгч компанийн хүсэлтийн дагуу гэрээний хугацааг сунгасан. Ажлын явц 70%. /Он дамжих ажил/

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
"Гидродизайн инноваци" ХХК	70%	15 950 000	14 970 690	0	979 310

4.3. Суманд хатуу хучилттай засмал зам тавих зураг төсөв боловсруулах ажлын Үнэлгээний хороог Засаг даргын 2019.05.21-ний А/67 дугаар захирамжаар байгуулж, зөвлөх үйлчилгээний цахим тендерийг 2019 оны 06, 08 дугаар саруудад зарлаж амжилтгүй болсон.

Тендерийн зарлалыг 2019.09.10-ны өдөр дахин зарлаж, хураангуй жагсаалтад орсон 3 байгууллагад зөвлөх үйлчилгээний тендерийн урилгыг хүргүүлсэн. Тендерийг 2019 оны 10 сарын 28-ны өдөр нээж үнэлэн "Ихэр мөнх" ХХК-г сонгон шалгаруулж, 2019.11.25-ны өдөр гэрээ байгуулсан. Ажлын явц 70%-тай явагдаж байна. /Он дамжих ажил/

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
"Ихэр мөнх" ХХК	30%	18 950 000	16 080 432	0	2 869 568

4.4. Шивээговь суманд 1:1000-ны масштабтай байр зүйн зураг үйлдэх, боловсруулах ажлыг "Шинэ геодези" ХХК-тай 2019 оны 03 сарын 12-ны өдөр 2.6 сая төгрөгийн гэрээ байгуулж, сумын 2-р багийн нутаг дэвсгэрт орших 21-р зөрлөгийн баруун урд 50 га газарт гэр бүлийн хэрэгцээний зориулалттай өмчлөлийн газарт байр зүйн зургийн ажлыг гүйцэтгүүлэн сумын Засаг даргын 2019 оны 03 сарын 19-ний өдрийн А/34 дугаар захирамжаар томилогдсон ажил хүлээн авах комисс 2019.03.29-ний өдөр хүлээж авсан.

Гэрээ байгуулсан оролцогч	Ажлын гүйцэтгэл	Батлагдсан төсөв	Гэрээлсэн дүн	Олгогдсон санхүүжилт	Хэмнэсэн өртөг
"Шинэ геодези" ХХК	100%	2 600 000	2 600 000	2 600 000	-

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР